



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 437

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг
сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 12 нэрийн, нийт 12,682,980.00 (арван хоёр сая зургаан зуун наян хоёр мянга есөн зуун наян) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,810,000.00 (нэг сая найман зуун арван мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Амарбаясгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002065

21-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн
497 дугаар тогтоолын хавсралт

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ ҮНИЙГ ШИНЭЧЛЭН
ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэм жих нэгж	Ашиглалтад орсон огноо	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)		
							Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Хэвлэгч /3 үйлдэлтэй HP 135A/	398,990.00	ш	2020-12-28	1	398,990.00	2	100,000.00	100,000.00
2	Хэвлэгч /3 үйлдэлтэй HP 135A/	398,990.00	ш	2020-12-28	1	398,990.00	2	100,000.00	100,000.00
3	Хэвлэгч /3 үйлдэлтэй HP 135A/	398,990.00	ш	2020-12-28	1	398,990.00	2	100,000.00	100,000.00
4	Зөөврийн компьютер /apple iPad/	1,519,650.00	ш	2020-12-28	1	1,519,650.00	2	300,000.00	300,000.00
5	Камерын тоноглох кейс	600,000.00	ш	2020-12-28	1	600,000.00	2	120,000.00	120,000.00
6	Камерын тоноглох кейс	600,000.00	ш	2020-12-28	1	600,000.00	2	120,000.00	120,000.00
7	Камерын дүрсний карт	600,000.00	ш	2020-12-28	1	600,000.00	2	120,000.00	120,000.00
8	Камерын дүрсний карт	600,000.00	ш	2020-12-28	1	600,000.00	2	120,000.00	120,000.00
9	Камерын зай манут	1,200,000.00	ш	2020-12-28	1	1,200,000.00	1	150,000.00	150,000.00
10	Гэрэл аппаратур	2,743,180.00	ш	2020-12-28	1	2,743,180.00	2	200,000.00	200,000.00
11	Гэрэл аппаратур	2,743,180.00	ш	2020-12-28	1	2,743,180.00	2	200,000.00	200,000.00

12	Санхүүгийн програм /asscolous/	880,000.00	ш	2020-11-10	1	880,000.00	2	180,000.00	180,000.00
	Нийт дүн					12,682,980.00 (арван хоёр сая зургаан зуун наян хоёр мянга есөн зуун ная)			1,810,000.00 (нэг сая найман зуун арван мянга)